



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 520

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газар түүний харьяа салбар нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 9776 нэрийн, нийт 78,844,074,583.78 (далан найман тэрбум найман зуун дөчин дөрвөн сая далан дөрвөн мянга таван зуун наян гурван төгрөг далан найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 23,121,325,660.88 (хорин гурван тэрбум нэг зуун хорин нэгэн сая гурван зуун хорин таван мянга зургаан зуун жаран төгрөг наян найман мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Д.Мөнхнасан, харьяа салбар нэгжийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн  
820 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, САЛБАР НЭГЖИЙН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ,  
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ДҮН (ТӨВЧӨӨ)

№	Байгууллагын нэр	Нэр төрөл	Тоо ширхэг	Балансын үнэ Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Шинээр тогтоосон үнийн дүн /төгрөг/	Цаашид ашиглах хугацаа /жилээр/
1	Иргэний нисэхийн ерөнхий газар - 01	776	784	933,302,768.99	315,681,003.87	2
2	Иргэний нисэхийн үндэсний төв -02 салбар	2554	2956	11,959,691,710.13	3,091,431,377.40	2
3	Аюулгүй байдал, хамгаалалтын алба	216	325	217,920,704.33	70,833,023.18	2
4	Холбоо, навигаци, ажиглалтын алба - 05 салбар	1709	2011	15,450,359,349.60	5,477,501,589.57	2
5	Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах алба	240	381	308,655,982.69	94,644,954.77	2
6	Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба	80	83	8,278,760,522.00	2,271,053,311.00	2
7	"Буянт ухаа" Олон улсын нисэх буудал	626	2755	3,868,663,874.14	821,857,832.75	2
8	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба	662	783	2,135,386,381.00	671,650,033.53	2
9	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба	350	371	4,410,037,717.59	1,830,902,494.38	2
10	Баянхонгор аймгийн нисэх буудал	188	365	1,171,304,360.63	366,725,844.02	2
11	Баян-Өлгий аймгийн нисэх буудал	128	265	1,282,155,324.37	399,884,586.97	2
12	Булган аймгийн нисэх буудал	114	135	804,753,677.72	188,704,037.78	2
13	Говь-Алтай аймгийн нисэх буудал	93	109	1,301,148,062.09	433,840,786.66	2
14	Дорнод аймгийн нисэх буудал	270	411	2,692,614,303.03	835,243,565.73	2
15	Дундговь аймгийн нисэх буудал	93	181	768,492,308.14	215,397,364.06	2
16	Завхан аймаг дахь Отгонтэнгэр нисэх буудал	204	387	1,303,708,543.32	364,550,181.61	2
17	Өвөрхангай аймгийн нисэх буудал	256	829	2,530,730,038.49	719,811,449.74	2
18	Өмнөговь аймгийн нисэх буудал	214	553	2,249,438,232.94	612,183,555.41	2
19	Хөвсгөл аймгийн нисэх буудал	252	349	5,142,964,385.19	1,462,805,628.19	2
20	Ховд аймгийн нисэх буудал	180	200	6,250,992,337.78	1,104,994,066.22	2
21	Хэнтий аймгийн нисэх буудал	82	100	1,043,226,945.63	276,158,396.50	2
22	Сүхбаатар аймгийн нисэх буудал	126	198	950,957,189.90	259,577,836.67	2
23	Завхан аймаг дахь Тосонцэнгэл нисэх буудал	125	135	1,102,961,895.10	346,316,051.40	2
24	Увс аймгийн нисэх буудал	238	352	2,685,847,968.98	889,576,689.47	2
			15018	78,844,074,583.78	23,121,325,660.88	2
	Нийт дүн	9776		(далан найман тэрбум найман зуун дөчин дөрвөн сая тусгай зориулалтын хөрөнгө)	(хорин гурван тэрбум нэг зуун хорин нэгэн сая гурван зуун тусгай зориулалтын хөрөнгө)	